



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 672

танай ны № т

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ
СҮМҮН СОНГУУЛИЙН ХОРООНД

Сонгуулийн мэрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Б.Оюун-Эрдэнийн сонгуулийн мэрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мэрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мэрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мэрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021345

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт


Бие даан нэр дэвшигч иргэн Б.Оюун-Эрдэнэ Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Б.Оюун-Эрдэнийн мөрийн хөтөлбөр (...хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Б.Оюун-Эрдэнэд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ



**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СУМЫН
ИРГЭН БАТСАЙХАНЫ ОЮУН-ЭРДЭНИЙ
ОРОН НУТГИЙН СОНГУУПЬД БИЕ ДААН
НЭР ДЭВШИХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Иргэн: Б.Оюун-Эрдэнэ

**Булган аймаг, Баян-агт сум, Шарга баг
2024 он**

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ ИРГЭН БАТСАЙХАНЫ ОЮУН-ЭРДЭНИЙ
2024 ОНЫ АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэгт хамрагдалтыг өсгөж тогтмолжуулах бодлого баримтална
- 1.2 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх бодлого баримтална
- 1.3 Хүүхэд бие бялдар зөв дадал эзэмшиүүлэх зорилгоор стандартын тогтоолын талбайг сургуулийн орчимд байгуулах бодлого баримтална.

Хоёр. Боловсрол

- 2.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд сурах орчин бүрдүүлэх бодлого баримтална
- 2.2 Спорт заал, дотуур байр, сургуулийн давхар бүрт коридорт хүүхэд ус уух боломжоор хангагдсан ус буцалгагч байршуулах бодлого баримтална
- 2.3 Сурагчдын дотуур байрны зөвлөн эдлэл, ширээ сандал, шкафыг шинэчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 2.4 Дотуур байрны гал тогоог стандарт болгох бодлого баримтална
- 2.5 Багшийг туршлага судлуулах, шинэ арга барил ^{ГҮА744700} ГЮА0048 3190269 зориулж багш солилцооны төсөл хэрэгжүүлэх бодлого баримтална

Турав. Нийгмийн хамгаалал

- 3.1 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох зорилгын хүрээнд сургалт зохион байгуулах бодлого баримтална

Дөрөв. Эрчим хүч

- 4.1 Сумын төвийн гадаа гэрэлтүүлгийг үе шаттай байгалийн сэргээгдэх эрчим ашиглан солих бодлого баримтална
- 4.2 Эрчим хүчний хэлбэлзэл ихтэй тогны хүчдэлийн уналт ихтэй газарт трансформатор суурилуулах бодлого баримтална

Тав. Аялал жуулчлал

- 5.1 Хануй, цагаан голын рашааны хүрмэнд оруулсан нойлын үйл ажиллагааг гэрээ байгуулан иргэн, аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан хариуцуулан өгөх бодлого баримтална
- 5.2 Хануй, цагаан голын рашаан, Шарга нуурт морь, сарлаг унуулах үйлчилгээг бий болгох
- 5.3 Нүүдлийн аж ахуй өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, малчин өрийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “малчин айлын гэр түрээс” бий болгох бодлого баримтална
- 5.4 Орон нутгийн онцлогийг шингээсэн гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж аялагч, жуулчдад худалдаалах нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтална

5.5 Малын гаралтай бүтээгдэхүүнийг ашиглан Баян-Агт сумын нэрийн бүтээгдэхүүнийг бий болгож, байнгын болон түр үйл ажиллагаа явуулдаг дэлгүүрүүдэд тогтмол худалдаалах нөхцөл бүрдүүлэх бодлого баримтална

Зургаа. МАА, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

- 6.1 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх бодлого баримтална
- 6.3 Малын тоо толгойн албан татвараар хийгдэж байгаа ажлуудыг иргэдэд сурталчилна таниулж, тэдний бодит саналд тулгуурласан ажил үйлчилгээг төлөвлөх бодлого баримтална
- 6.4 Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хэрэглээг сургууль, цэцэрлэгийн үдийн хоолонд нэмэгдүүлэх бодлого баримтална
- 6.5 Сургуулийн орчинд сурагчдад эрүүл, чанартай, хямд хоол цайгаар үйлчлэх цайны газар бий болгох бодлого баримтална

Долоо. Нийгмийн бусад

- 7.1 Ахмадын байранд эрүүл хөдөлгөөн хийх тоног төхөөрөмжийг суурилуулах бодлого баримтална
- 7.2 Эрчим хүчний хэмнэлттэй байгаль орчинд ээлтэй амины орон сууц барих, засварлахад байгалийн түгээмэл тархацтай баялаг /элс, хайрга/-аас авах төлбөр хураамжаас чөлөөлөх, эрх зүйн мэдээллийг түгээн дэлгэрүүлэх бодлого баримтална
- 7.3 Хогийг эх үүсвэр дээр нь ангилах бодлого баримтална
- 7.4 Төрийн албан хаагчдыг ажлын байрандаа ажиллангаа өөрийн албан тушаалын чиглэлээр суралцахыг дэмжих бодлого баримтална